



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2009 оны 06 сарын 09 өдөр

Дугаар A/948

Мандалговь

Өмнө нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамtran  
өмчилсөн газрыг гэр бүлийн нэг гишүүнд  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Сайнцагаан сумын гэр хороололд 2008 оны 05 дугаар сарын 01-нээс өмнө гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан газар нэг удаа үнэгүй өмчилж гэр бүлийн гишүүд нэгэндээ газар өмчлөх эрхээ шилжүүлсэнтэй холбогдуулж газар өмчлөх эрх шилжүүлж авсан 1 иргэний нэр, газрын байршил, хэмжээ, үнэлгээг хавсралтаар баталсугай.
2. Аймгийн хэмжээнд 2008 онд кадастрын зураглал хийгдсэнтэй холбогдуулан зарим иргэдийн газрын хэмжээг зурагт орсноор өөрчлөн шилжүүлэх, газар өмчлөгчийн хуулийн дагуу хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Сайнцагаан сумын Засаг дарга (С.Бат-Оргил), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (Э.Чагнаадорж) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2008 оны 77 дугаар захирамжийн хавсралтын 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.
4. Хамtran өмчлөх эрхээсээ татгалзсан иргэдэд хууль тогтоомжид заасны дагуу газар үнэгүй өмчлөх эрхээ эдлэх боломжтой болохыг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Ц.МӨНХБАТ

4822100507